



**“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ**

**ШУУРХАЙ АЖИЛЛАГААНЫ АЖИЛТНУУДЫГ СУРГАЖ ДАДЛАГАЖУУЛАХАД  
ШААРДЛАГАТАЙ 220 КВ-ЫН ЦДАШ, ДЭД СТАНЦЫН СУРГАЛТ ЯВУУЛАХ  
СИМУЛЯТОР ПРОГРАММ ХАНГАМЖ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН  
ШАЛГАРУУЛАХ ХАРЬЦУУЛАЛТЫН ДАХИН ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендерийн нэр: **Шуурхай ажиллагааны ажилтнуудыг сургаж  
дадлагажуулахад шаардлагатай 220 кВ-ын ЦДАШ, дэд станцын сургалт  
явуулах симулятор программ хангамж нийлүүлэх**

Тендерийн дугаар: **ЦДҮС-2019/ХА-80/Дахин**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2019 оны 11 дүгээр сарын 13

“Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос **“Шуурхай ажиллагааны ажилтнуудыг сургаж дадлагажуулахад шаардлагатай 220 кВ-ын ЦДАШ, дэд станцын сургалт явуулах симулятор программ хангамж нийлүүлэх”** тухай цахим үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх **техникийн тодорхойлолт/ажлын даалгавар** болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Энэхүү тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээр явагдах бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг доорх хаягаар авч болно.

Тендерийг 2019 оны **11 дүгээр сарын 20**-ны өдрийн **10:00** цагаас өмнө цахим системээр илгээх ба 2019 оны **11 дүгээр сарын 20**-ны өдрийн **10:10** цагт цахимаар нээнэ.

**Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-22/1, “ЦДҮС” ТӨХК-ийн төв байр, 3 дугаар давхар 309 тоот.**

**Худалдан авах ажиллагаа, Ханган нийлүүлэлтийн хэлтэс.**  
**Утас: 99187460, Email: [a.chinbat@transco.mn](mailto:a.chinbat@transco.mn)**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
  2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
  3. Тендерийн иж бүрдэл
  4. Тогтмол үнэ
  5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
  6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
  7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
  8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гүйцэтгэсэн бараа, ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) Программ хангамж дагалдах үйлчилгээний жагсаалт;
    - (е) Шаардлагатай оюуны өмчийн эрх;
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
  - 5.1. Нийлүүлэх программ хангамж нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх программ хангамж нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
  - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, программ хангамж боловсруулах, суурилуулах, тохируулах болон зүгшрүүлэх зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
  - 7.2. Программ хангамж нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
  - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
  - 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> <li>- Татварын цахим тодорхойлолт</li> <li>- Сүүлийн нэг жилийн санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/;</li> <li>- Сүүлийн нэг жилийн туршлагын мэдээлэл /гүйцэтгэсэн бараа, ажлын гэрээний хуулбар/;</li> <li>- Улсын бүртгэлийн гэрчилгээ; /нотариатаар баталгаажуулна/</li> <li>- Компанийн танилцуулга;</li> <li>- Санал болгож буй программ хангамжын дэлгэрэнгүй танилцуулга, техникийн тодорхойлолт;</li> <li>- Ажиллах хүчин, мэргэжлийн ур чадварыг тодорхойлох мэдээлэл;</li> </ul> <p>Дээрх баримт материалыг ирүүлээгүй, ирүүлсэн материал дутуу бөгөөд үнэн зөв эсэх нь нотлогдоогүй тохиолдолд тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: <b>шаардлаггүй</b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>  Огноо: Тендерийг <b>2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр</b>  Цаг: <b>10 цаг 00 минут.</b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:  Тендер нээх хаяг: <b>Улаанбаатар-17060, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-22/1, “ЦДҮС” ТӨХК-ийн Төв байр, 3 дугаар давхар, 309 тоот буюу цахим системээр нээнэ.</b>  Огноо: <b>2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр нээлт хийнэ.</b>  Цаг: <b>10 цаг 10 минут</b></p>
ТӨӨЗ 7.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>багцгүй</b></p>

## Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ/АЖЛЫН ДААЛГАВАР

### ДИСПЕТЧЕРИЙН СУРГАЛТЫН СИМУЛЯТОР ПРОГРАМ ХАНГАМЖИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Монгол Улсын цахилгаан эрчим хүчний хэрэглээ өсөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор шинээр дэд станц, шугам тоноглол ашиглалтад орох, одоо ашиглагдаж байгаа дэд станц, шугам тоноглолуудад өргөтгөл шинэчлэлт хийгдэж, шинэ техник технологи нэвтэрч байгаатай холбоотойгоор шуурхай ажиллагааны ажилтнуудыг сургалтад хамруулах, дадлагажуулах шаардлага зайлшгүй тулгарч байна.

Иймээс диспетчер инженерүүд болон шуурхай ажиллагааны ажилтнуудыг бодит схем дээр сэлгэн залгалт хийлгэх, реле хамгаалалт автоматикийн ажиллагаанд үнэлэлт дүгнэлт гаргах зэрэг сургалтуудыг явуулахад сургалтын симулятор программ хөгжүүлэх.

Энэхүү программыг шуурхай ажиллагааны ажилтнуудын сургалтад хэрэглэнэ.

#### **Програмд тавигдах шаардлага:**

- Javascript, CSS3, HTML5, DotNet, C# болон сүүлийн үеийн бусад технологи болон хэл дээр бичигдсэн веб орчинд ажиллах зориулалттай програм хангамж байх.
- MSSQL өгөгдлийн сан ашиглах
- Сервер дээр суурилуулж дотоод сүлжээ эсвэл интернет ашиглан програмыг ашиглах боломжтой байх.
- Орчин үеийн интернет хөтчүүдийг дэмждэг байх.
- Станцуудын схемийг өгөгдлийн санд хадгална. Өгөгдлийн сангаас схемийн мэдээллийг дуудаж хэрэглэгчид харуулдаг байх.
- Програмыг ашиглахын өмнө хэрэглэгчээс нэвтрэх нэр, нууц үг шаарддаг байх.
- Програмын хэрэглэгчдийн мэдээллийг өгөгдлийн санд байршуулна.

#### **Програм хангамжид хийгдэх үйлдлүүд:**

- Шуурхай сэлгэн залгалтын үйлдлүүдийг хийх
- Шуурхай сэлгэн залгалтын буруу үйлдлүүдийг хийхийг хориглох үйлдлүүдийг оруулж өгөх
- Тоноглолын шуурхай ажиллагааны нэршил, Фиксацийн горим
- Гүйдэл, чадлын урсгалыг бодитоор харуулах, тасралт гарсан үед гүйдэл, чадлын урсгалын шилжилтийг харуулах
- Реле хамгаалалтын тавилын карт, ажиллагаа

- Цахилгаан энерги, горимын тооцоо болон хүчдэл, давтамжийн түвшин
- Инженерчлэлийн нарийвчилсан тооцоо, вектор диаграмм хийх
- Шаардлагатай гэж үзвэл 3D хөдөлгөөнт дүрслэлээр сэлгэн залгалтын үйлдлүүдийг бодитоор үзүүлж симуляц хийж хөгжүүлэх боломжтой.
- Scada болон HMI системтэй холбогдож мэдээллийг авах боломжтой
- Тоноглолуудаас дискрет болон аналог сигналуудыг авч боловсруулах, дурын схем, модель үүсгэх боломжтой

#### **Програм хангамжид оруулах нарийвчилсан үйлдлүүд:**

- Сэлгэн залгалтын буруу үйлдэл (хэмжүүр ажилаагүй, хориг ажилаагүй, дохиолол ирээгүй, хүний буруутай үйлдэл гэх мэт) хийсэн тохиолдолд ямар осол, аваар саатал гарч болохыг харуулах, ямар арга хэмжээ авахыг үзүүлэх.
- ОРУ-гын аль нэг холболтын цэг дээр зөөврийн болон байнгын газардуулга залгаатай үед шууд хүчдэл өгсөн тохиолдолд гарах аваарын процессыг үзүүлэх, үүсэх хор хөнөөлийг тодорхойлж харуулах.
- 110, 220 кВ-ын хуурай салгуурыг ачаалалтай таслах үед ямар аваарын процесс явагдахыг үзүүлэх, ямар хамгаалалтууд ажиллах, урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээ авахыг үзүүлэх.
- Тухайн дэд станцаас гарч байгаа систем үүсгэгч шугам дээр богино залгаа гарч үндсэн хамгаалалт ажилаагүй тохиолдолд ямар хамгаалалтууд ажиллаж болох, ямар хор хөнөөл учрахыг харуулах гэх мэт.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ХЭЛТЭС

ШУУРХАЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТЭС

**ПРОГРАММ ХАНГАМЖЫН ЖАГСААЛТ БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан программ хангамж хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон программ хангамж нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
220 кВ-ын ЦДАШ, дэд станцын сургалт явуулах симулятор программ хангамж	Шуурхай ажиллагааны ажилтнуудыг сургаж дадлагажуулахад шаардлагатай	<b>1</b>	Иж бүрэн	ЦДҮС ТӨХ-ийн Төв байр, ШЗХ болон МТХ	7 хоног	14 хоног	

Тав. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

**Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу танаа**

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан программ хангамжыг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх программ хангамж нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Программ хангамж-ын гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ, ₮	Нийт дүн, ₮	НӨАТ болон бусад албан татвар, ₮	Бүгд дүн, ₮
1	2	3	4	5	6	7	8
220 кВ-ын ЦДАШ, дэд станцын сургалт явуулах симулятор программ хангамж		Монгол	1 иж бүрэн				
Тендерийн нийт үнэ, ₮							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:



## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| 1. Шалгах болон турших  | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Программ хангамжын нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх программ хангамж нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн программ хангамжын гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх   | 3.1. Программ хангамж, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.   |
| 4. Программ хангамж хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                                 | 5.1. Нийлүүлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>1</b> жил байна.  |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                                   | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх программ хангамжын нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.  |
| 7. Төлбөр   | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>(ГТН-д заасан тоо)</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Программ хангамж нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч программ хангамжыг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах   | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн программ хангамж, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.   |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах                    | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 11. Маргааныг шийдвэрлэх                                      | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
  - 1.1. Программ хангамжыг хүлээн авахаас өмнө ЦДҮС ТӨХК-ийн Шуурхай зохицуулалтын хэлтэс, Мэдээллийн технологийн хэлтэс, Техникийн бодлого зохицуулалтын хэлтэс, Худалдан авах ажиллагаа, ханган нийлүүлэлтийн хэлтсээр шалгуулна.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
  - 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх баримт бичгүүд:
    - 1) нийлүүлэгчийн программ хангамжын нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
    - 2) барааг хүргэсэн, угсарч суурилуулсан, туршиж шалгасан, зүгшрүүлсэн тухай баримт;
    - 3) Нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
    - 4) Эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
    - 5) Программ хангамжын гарал үүслийн гэрчилгээ.

Энд жагсаасан баримт бичгийг программ хангамж нийлүүлэхээс ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
  - 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.

Чанарын баталгаат хугацаа 12 сар байна. Баталгаат засварын барьцаа гэрээний үнийн дүнгийн 5 хувь байх бөгөөд гэрээ дүгнэсэн өдрөөс хойш 6 сарын дараа олгоно.
4. Төлбөр (ГЕН – 7)
  - 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн **95** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө. Эцсийн төлбөрийг баталгаат засварын баталгааны хугацаа дууссаны дараа олгоно.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)
  - 9.1. Алданги оногдуулах хувь: Хоног тутамд гэрээний үнийн дүнгийн **0.05%** байна.

Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн **5%**-иас хэтрэхгүй.

Найм. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>1</sup>

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ ТӨХК** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг  
Үнийн санал;

\_\_\_\_\_

Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*